Орхон аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс

СТАТИСТИКИЙН БЮЛЛЕТЕНЬ

MONTHLY BULLETIN OF STATISTICS

7 сар
2013
July

Эрдэнэт хот

2013 он

АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН 2013 ОНЫ ЭХНИЙ 07 САРЫН ДҮНГИЙН ТАНИЛЦУУЛГА

Эрдэнэт хот **2013 он**

1.Макро эдийн засаг

Төсөв санхүү

Аймгийн төсөвт 21.3 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 106.5 хувьтай байна.

Татварын бус орлого 3.0 дахин, татварын орлого 5.9 хувиар давж биелсэн байна. Нийт орлогын 0.9 хувийг татварын бус орлого, 99.1 хувийг татварын орлого эзэлснээс 56.0 хувийг орлогын албан татвар, 15.2 хувийг өмчийн татвар, 2.9 хувийг тусгай зориулалтын орлого, 25.9 хувийг бусад татвар эзэлж байна.

Орон нутгийн төсвөөс төлөвлөгөөт зарлагын 93.9 хувь буюу 25.5 тэрбум төгрөгийн зарлага санхүүжилт хийсний 4.6 хувийг нийгмийн даатгалын шимтгэлд, 12.4 хувийг хөрөнгийн зардалд, 16.6 хувийг бараа үйлчилгээний зардалд, 23.9 хувийг татаас ба урсгал шилжүүлэгт, 42.5 хувийг цалин хөлсний зардалд зарцуулжээ.

Салбарын хувьд хөдөө аж ауй, ойн аж ахуйн салбарт 0.1 хувийг, эдийн засгийн бусад салбарт 0.8 хувийг, амралт спорт урлагийн салбарт 2.2 хувийг, эрүүл мэндийн салбарт 2.8 хувийг, нийтийн ерөнхий үйлчилгээнд 13.3 хувийг, ангилагдаагүй бусад зардалд 15.6 хувийг, нийгмийн даатгал, нийгмийн халамжийн салбарт 17.3 хувийг, боловсролын салбарт 47.7 хувийг зарцуулсан байна.

Банк, мөнгө, зээл

Монгол банкны мэдээгээр 828.0 тэрбум төгрөгийг гүйлгээнээс татаж, 895.8 тэрбум төгрөгийг гүйлгээнд гаргасан байна. Өнгөрсөн оны мөн үеэс гүйлгээнээс татсан төгрөгийн хэмжээ 10.6 хувиар, гүйлгээнд гаргасан төгрөгийн хэмжээ 9.7 хувиар нэмэгджээ.

Иргэдийн хувийн мөнгөн хадгаламж 99.4 тэрбум төгрөг болж, аймгийн нэг хүнд дунджаар 1099667 төгрөгийн, нэг хадгаламж эзэмшигчид 1174129 төгрөгийн хадгаламж ногдож байна. Өнгөрсөн оны мөн үеэс хадгаламжийн үлдэгдэл 15.8 хувиар, хадгаламж эзэмшигчийн тоо 14.9 хувиар өсчээ.

Үнэ

Хэрэглээний үнэ тарифын судалгааг хэрэглээний сагс дахь 213 нэр төрлийн бараа үйлчилгээнд хийлээ. Судалгааны дүнгээр үнийн ерөнхий индекс энэ сард 99.6 хувь болж, өмнөх сараас 2.3 хувиар буурч, өнгөрсөн оны мөн үеэс 14.4 хувиар өсчээ.

7-р сард, орон сууц, хүнсний бараа, амралт чөлөөт цаг соёлын бараа, бүлгийн индекс 0.7-1.5 хувиар буурч, гутал хувцас бөс бараа, холбооны хэрэгсэл шуудангийн үйлчилгээ 0.1-1.1 хувиар өсчээ. Харин гэр ахуйн бараа, эм тариа эмнэлгийн үйлчилгээ, тээвэр, боловсролын үйлчилгээ, бусад бараа үйлчилгээний бүлгийн индекс өмнөх сарын түвшинд байна.

Ажилгүйдэл

Тайлант хугацаанд Хөдөлмөрийн хэлтэст 1892 хүн бүртгэлтэй байгаагийн 56.3 хувь нь эмэгтэйчүүд ба бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо өнгөрсөн оны мөн үеэс 3.8 хувиар буюу 70 хүнээр их байна.

Нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн 2.0 хувь нь 45-59 насныхан, 11.8 хувь нь 35-44 насныхан, 42.8 хувь нь 15-24 насныхан, 43.4 хувь нь 25-34 насныхан байна.

Бүртгэгдсэн ажилгүйчүүдийн 25.2 хувь нь сургууль төгссөн, 5.1 хувь нь өөр газраас шилжиж ирсэн, 3.0 хувь нь байгууллага татан буугдсан, 2.3 хувь нь орон тооны цомхотголоор, 1.3 хувь нь цэргээс халагдсан шалтгаанаар ажил хайж бүртгүүлжээ.

Эдгээрээс тайлант хугацаанд 1860 хүн ажилд орсноос худалдааны салбарт 12.0 хувь, боловсруулах үйлдвэрлэлд 19.0 хувь, үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарт 28.3 хувь ажилд орсон нь дийлэнх хувийг эзэлж байна.

2. Нийгмийн үзүүлэлт

Нийгмийн халамж, даатгал

Аймгийн дүнгээр давхардсан тоогоор 46.1 мянган хүнд 21.8 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлт олгосноос 2.2 мянган хүнд 1.4 тэрбум төгрөгийн халамжийн тэтгэвэр, 1.9 мянган хүнд 580.7 сая төгрөгийн нөхцөлт мөнгөн тэтгэмж, нийгмийн дэмжлэг туслалцаа шаардлагатай 2.8 мянган хүнд 442.3 сая төгрөгийн хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж, 4.7 мянган ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд 190.0 сая төгрөгийн тусламж, хөнгөлөлт, хүн амын хөгжлийг дэмжих чиглэлийн улсын төсвийн санхүүжилтээр 9.6 мянган хүнд 1.4 тэрбум төгрөгийн тэтгэмж, хөнгөлөлт, Хүний хөгжлийн сангаас 11.1 мянган хүнд

820.6 сая төгрөгийн хишиг хувийг олгожээ. Өнгөрсөн оны мөн үеэс халамжийн үйлчилгээнд хамрагдсан хүн 65.1 хувиар, олгосон халамжийн хэмжээ 40.4 хувиар буурсан нь Хүний хөгжил сангаас хишиг мөнгийг бүх хүмүүст олгохгүй болсонтой холбоотой байна.

Нийгмийн даатгалын сангийн орлогод 28.4 тэрбум төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөө 113.7 хувиар биелсэн ба бүх сангуудын орлогын төлөвлөгөө 7.0-15.7 хувиар давж биелжээ. Сангийн орлого өнгөрсөн оны мөн үеэс 38.2 хувиар нэмэгдсэн байна.

642 хүнд шинээр тэтгэвэр тогтоосноос 65.4 хувьд нь өндөр насны, 26.8 хувьд нь тахир дутуугийн, 7.8 хувьд нь тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоожээ. Тэтгэвэр тогтоолгосон хүний тоо өнгөрсөн оны мөн үеэс 49.7 хувиар нэмэгдсэн байна.

Эрүүл мэнд

Эрүүл мэндийн байгууллагууд давхардсан тоогоор 354.2 мянган хүнд үзлэг хийснээс 37.5 хувийг нь урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан байна. Өнгөрсөн оны мөн үеэс нийт үзлэг 31.5 хувиар, урьдчилан сэргийлэх үзлэг 23.5 хувиар нэмэгджээ.

Сэргийлэх тарилгад 9.8 мянган хүн хамрагдсан нь нийт хамрагдвал зохих хүний 99.2 хувь нь бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс хамралт 0.4 пунктээр өссөн байна.

Эрүүл мэндийн газрын мэдээгээр аймгийн хэмжээнд 1602 эх амаржин, 294 хүн нас баржээ. Нас баралтын 5.1 хувийг нялхсын нас баралт эзэлж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл 7.2 промилээр, 1000 хүнд ногдох нас баралт 0.6 промилээр буурч, төрөлт 1.4 промилээр нэмэгджээ.

Халдварт өвчнөөр өвчилсөн 461 тохиолдол гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 20.0 хувиар буюу 13.5 продицимилээр буурсан байна. Нийт өвчлөлтийн 14.3 хувийг сүрьеэ, 12.6 хувийг мөөгөнцөр, 10.8 хувийг халдварт шар, 7.8 хувийг салхинцэцэг, 7.6 хувийг гахай хавдар, 3.5 хувийг суулгалт халдвар, 1.7 хувийг цусан суулга, 2.0 хувийг хоолны ходлого, 1.5 хувийг хамуу, 34.1 хувийг бэлгийн замын халдварт өвчин, үүний 65.6 хувийг тэмбүүгээр, 26.8 хувийг трихоманазаар, 7.6 хувийг заг хүйтнээр өвчлөгсөд эзэлж байна.

Өнгөрсөн оны мөн үеэс 10000 хүнд ногдох заг хүйтэн 0.5, бруцеллез 2.8, мөөгөнцөр 3.7, халдварт шар 12.7 продицимилээр буурч, хамуу, ёлом өнгөрсөн оны

мөн үеийн түвшинд байж, бусад халдварт өвчний гаралт 0.1-1.7 продицимилээр нэмэгдсэнээс гахай хавдар 1.7 продицимилээр нэмэгджээ.

Урд оны мөн үед гарч байсан энтеровирусын халдвараар өвчилсөн тохиолдол гараагүй байна. Харин өмнөх оны мөн үед гарч байгаагүй гар, хөл, амны өвчнөөр өвчилсөн 1, сальмонеллёзоор өвчилсөн 2, хачигт риккетиозоор өвчилсөн 2, хачигт энцефалитаар өвчилсөн 7, эмнэлгийн дотоод халдварын 2 тохиолдол гарчээ.

Сахилга дэг журам

Цагдаагийн газрын мэдээгээр 358 хэрэгт 282 хүн холбогдон шалгагдаж, хэргийн илрүүлэлт 51.5 хувьтай байна. Өнгөрсөн оны мөн үеэс бүртгэгдсэн хэрэг 27.4 хувиар, 18 –аас дээш насны 10000 хүнд ногдох гэмт хэрэг 11.9 продицимилээр өсч, холбогдогч 4.4 хувиар буурч, хэргийн илрүүлэлт 14.0 пунктээр бага байна.

Нийт бүртгэгдсэн хэргийн 46.1 хувь нь бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэрэг, 34.6 хувь нь согтуугаар үйлдэгдсэн хэрэг, 6.7 хувь нь хүнд, онц хүнд хэрэг байгаа ба өнгөрсөн оны мөн үеэс согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн тоо 0.8 хувиар, хүнд, онц хүнд хэрэг 42.9 хувиар буурч, харин бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэрэг 38.7 хувиар нэмэгджээ.

Бүртгэгдсэн хэргүүдийг өнгөөр нь авч үзвэл нийт хэргийн 37.4 хувийг хулгайн хэрэг, 33.8 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах хэрэг, 6.4 хувийг залилан мэхлэх, завшиж үрэгдүүлэх хэрэг, 6.1 хувийг хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг хэрэг хэрэг, 3.6 хувийг танхай, 1.7 хувийг дээрмийн хэрэг, 1.7 хувийг хүн амины хэрэг эзэлж байна.

Өнгөрсөн оны мөн үеэс хүн амины хэрэг 14.3 хувиар, малын хулгай 28.6 хувиар, танхай 43.5 хувиар, дээрэм 45.5 хувиар, албан тушаалын хэрэг 50.0 хувиар, хүчингийн хэрэг 83.3 хувиар буурч, бусад хэргийн гаралт 11.1%-2.2 дахин нэмэгдсэнээс иргэдийн өмчийн хугайн хэрэг 2.2 дахин нэмэгджээ.

Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 415.7 сая төгрөгийн хохирол учирч, 16 хүн нас барж, 149 хүн хүнд хөнгөнөөр гэмтсэн ба нийт хохирлын 38.9 хувийг нь нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэрэгт холбогдсон 282 хүний 63.5 хувь нь эрхэлсэн ажил хөдөлмөргүй, 38.3 хувь нь согтуугаар, 23.8 хувь нь бүлэглэн гэмт хэрэг үйлдсэн ба 12.8 хувь нь 18 хүртэл насны хүүхэд байна.

Хэв журмын нөхцөл байдлын хувьд хутгатай холбоотой 55 зөрчил гарч, 3.1 мянган хүн эрүүлжигдэн, 540 хүн захиргааны шийтгэлээр баривчлагдсан нь өнгөрсөн оны мөн үеэс хутга мэстэй холбоотой зөрчил 8.3 хувиар, эрүүлжүүлэгдсэн хүний тоо 2.4 хувиар буурч, баривчлагдсан хүний тоо 3.1 хувиар нэмэгджээ.

Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодон замын хөдөлгөөнд оролцож байсан 1071 жолоочийг илрүүлэн, 738 жолоочийн эрхийг тодорхой хугацаагаар хасч шийтгэжээ. Өнгөрсөн оны мөн үеэс согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодон замын хөдөлгөөнд оролцсон жолоочийн тоо 33.9 хувиар, эрх хасалт 1.8 хувиар нэмэгджээ.

3.Үйлдвэрлэл үйлчилгээний талаар.

Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарт 664.8 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн, 683.3 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн борлуулж өмнөх оны мөн үеэс үйлдвэрлэлт 7.5 хувиар, борлуулалт 6.4 хувиар буурсан байна.

Өнгөрсөн оны мөн үеэс үйлдвэрлэлт цахилгаан, дулааны үйлдвэрлэлийн салбарт 7.7%-иар, боловсруулах аж үйлдвэрийн салбарт 28.9%-иар өсч, уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт 8.8%-иар буурчээ.Уул уурхайн салбарын бууралт нь хүдэр дахь зэсийн баяжмалын агууламж буурсантай холбоотой ба энэ нь аймгийн нийт бүтээгдэхүүний бууралтад нөлөөлсөн байна.

Нийт бүтээгдэхүүний 94.5 хувийг уул уурхайн олборлох салбарт, 3.8 хувийг боловсруулах салбарт, 1.7 хувийг цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлийн салбарт үйлдвэрлэжээ.

Боловсруулах салбарын үйлдвэрлэлтийн 39.4 хувийг ноосон нэхмэлийн үйлдвэрлэл, 28.1 хувийг төмрийн үйлдвэрлэл, 11.3 хувийг хүнсний бүтээгдэхүүн, 10.6 хувийг төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл, 3.4 хувийг машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл, 3.2 хувийг оёдол, 1.9 хувийг резинэн болон хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл, 1.1 хувийг түлш үйлдвэрлэл, 0.7 хувийг хэвлэх үйлдвэрлэл, 0.2 хувийг мод, модон эдлэл үйлдвэрлэл, 0.003 хувийг гутал үйлдвэрлэл тус тус эзэлж байна.

Хүнсний бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэлтийн 32.0 хувь нь хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, 28.5 хувь нь сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, 22.3 хувь нь мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, 15.1 хувь нь гурил, тэжээлийн үйлдвэрлэлт, 2.1 хувь нь архи, ундаа үйлдвэрлэлт эзэлж байна.

Гол нэр төрлийн 60 бүтээгдэхүүнийг судалгаанд хамруулснаас катодын зэс, I гурил, цахилгаан эрчим хүч, хивс, хүснэгт маягт, ном,хиам, хайрга, хэвийн боов, пиво, тараг, бээлий, банш бууз хуушуур, дулаан эрчим хүч, вакуум цонх, хаалга, сонин, металл бэлдэц, нарийн боов, хөшиг, сүлжмэл эдлэл, хивэг, хийжүүлсэн цэвэр ус, боловсруулсан шингэн сүү, II гурил, гоймон, бялуу, хэрчсэн гурил, дайвар бүтээгдэхүүн, зэргийн үйлдвэрлэлт 1.6%-7.0 дахин өсч, бусад бүтээгдэхүүний үйлдвэрлэлт 0.3%-80.3%-иар буурсны дотор үхрийн махны үйлдвэрлэлт 80.3%-иар буурчээ.

Өнгөрсөн оны мөн үеэс үйлдвэрлэсэн дайвар бүтээгдхүүн 4.7 дахин өссөн нь “Эрдэнэт мах маркет” ХХК, “Эрдмийт” ХХК-г шинээр мэдээнд хамруулсантай холбоотой байна.

Өнгөрсөн оны мөн үед үйлдвэрлэгдэж байсан ямааны мах, архи, дарс, шавардлагын зуурмаг он гарсаар үйлдвэрлэгдээгүй ба цахилгаан дамжуулагч уртасгагч залгуурыг Эрдмин ХХК, дизелийн түлшийг Монпити ойл ХХК үйлдвэрлэж эхлээд байна.

Хөдөө аж ахүй

Оны эхний төллөх эх малын 89.6 хувь буюу 77.6 мянган хээлтэгч мал төллөж, гарсан төлийн 99.4 хувь нь бойжиж байна. Өмнөх оны мөн үеэс төллөлт 2.3 пунктээр, төл бойжилт 0.8 пунктээр их, төлийн хорогдол 53.4 хувиар бага байна.

Аймгийн хэмжээнд 1798 толгой том мал зүй бусаар хорогдож, мал онд оролт 99.03 хувьтай байна. Өмнөх оны мөн үеэс малын зүй бус хорогдол 14.4 хувиар их, үүнээс өвчнөөр хорогдсон мал 84.8 хувиар, чононд идүүлсэн мал 9.4 дахин нэмэгджээ. Нийт хорогдсон малын 54.2 хувь нь хонь, 33.4 хувь нь ямаа, 7.5 хувь нь үхэр, 4.9 хувь нь адуу байна.

Баян-Өндөр сумын төллөх эх малын 88.9 хувь, Жаргалант сумын төллөх эх малын 91.4 хувь нь төллөж , гарсан төлийн 99.4-99.6 хувь нь бойжиж байна.

Баян-Өндөр суманд 1501 толгой том мал зүй бусаар хорогдсон нь аймгийн нийт хорогдлын 83.5 хувийг эзэлж байна.

Хаврын тариалалтаар аж ахуйн нэгж, 1195 өрх, иргэд 3771.5 га-д үр тариа (үүнээс 3582.0 га-д улаан буудай, 159.5 га-д овьёос, 2.0 га-д хөх тариа, 26.0 га-д арвай, 2.0 га-д бог будаа) 331.1 га-д төмс, 230.5 га-д хүнсний ногоо тариалжээ. Үр тарианы төлөвлөгөөт зорилт 98.4 хувь, төмс 72.8 хувь, хүнсний ногоо 56.8 хувьтай

байна. Үр тарианы 54.8 хувь, төмсний 31.5 хувь, хүнсний ногооны 18.4 хувийг гадны аймгийн нутаг дэвсгэрт тариалжээ.

Барилга

Их барилгын аж ахуйн нэгжүүд 12.5 тэрбум төгрөгийн барилга угсралт их засварын ажлыг 64 обьектод хийж гүйцэтгэсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 29.2 хувиар нэмэгдсэн ба нийт ажлын 53.8 хувь нь их засварын ажил байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 45 объектод 2.5 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 3.3 дахин их байна.

Тээвэр, холбоо

Тээврийн байгууллагууд 40.7 мянган тн ачаа тээвэрлэн, 13.4 сая.тн/км-ийн ачаа эргэлт, 4.7 сая зорчигч тээвэрлэн, 69.0 сая хүн/км–ийн зорчигч эргэлт хийж, тээврийн үйлчилгээнээс 7.5 тэрбум төгрөгийн орлоготой ажиллажээ. Өнгөрсөн оны мөн үеэс тээврийн орлого 61.7, ачаа эргэлт 11.0 хувь, тээсэн ачаа 10.4 хувь, зорчигч эргэлт 0.3 хувиар өсч, тээсэн зорчигч 0.1 хувиар буурсан байна. Зорчигч тээврийн үйлчилгээнд 225 микроавтобус, 462 такси гарч тэдгээрт 927 хүн ажиллаж байна.

Холбооны байгууллагууд 3.7 тэрбум төгрөгийн тарифын орлоготой ажилласны 89.8 хувийг хүн амын үйлчилгээний орлого эзэлж байна. Өнгөрсөн оны мөн үеэс нийт орлого 54.3 хувиар буурсан нь үүрэн телефоны үйлчилгээний орлого багассанаас шалтгаалжээ. Энэ нь зарласан хөнгөлөлт, урамшуулалт нэмэгдсэн, үйлчилгээний тариф буурсан, дугаарын борлуулалтын хэмжээ буурсантай холбоотой.

Интернетийн үйлчилгээний 8 цэг давхардсан тоогоор 57.6 мянган хүнд үйлчлилж, 32.8 сая төгрөгийн орлоготой ажиллажээ. Өмнөх оны мөн үеэс интернет үйлчилгээний орлого 77.3 хувиар нэмэгдэж, кабелийн телевизийн орлого 27.5 хувиар, үүрэн телефоны үйлчилгээний орлого 63.9 хувиар буурсан байна.

Худалдаа, үйлчилгээ

Аймгийн худалдаа нийтийн хоолны 803 цэг салбар 44.6 тэрбум төгрөгийн бараа гүйлгээ хийж, бараа гүйлгээний нийт хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 45.4 хувиар өсчээ.

Нийт бараа гүйлгээний 41.6 хувийг шатахуун борлуулалт, 36.7 хувийг хүнсний дэлгүүр, 7.8 хувийг цайны газар, 6.1 хувийг ресторан бар, 3.5 хувийг

барааны дэлгүүр, 1.8 хувийг эм борлуулалт, 1.2 хувийг контейнер, 0.5 хувийг барилгын материалын дэлгүүр, 0.5 хувийг авто засварын газар, 0.1 хувийг авто сэлбэгийн дэлгүүрийн орлого эзэлж байна.

Өнгөрсөн оны мөн үеэс авто засвар, эм болон шатахууны борлуулалт, контейнер, барааны дэлгүүр, ресторан бар, хүнсний дэлгүүрийн борлуулалтын орлого 8.4%-9.9 дахин өсчээ. Харин барилгын материал, ТҮЦ, авто сэлбэгийн дэлгүүрийн орлого 8.1-52.9 хувиар буурсан байна.

Нийтийн аж ахуйн болон ахуйн үйлчилгээ

Нийтийн ахуйн үйлчилгээний орлого 3.9 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 30.8 хувиар өссөн байна. Нийт орлогын 78.2 хувийг орон сууц, 13.7 хувийг зочид буудал, 4.9 хувийг хог тээвэрлэлт, 2.2 хувийг цэвэр ус борлуулалт, 1.0 хувийг халуун усны орлого бүрдүүлж байна. Өнгөрсөн оны мөн үеэс орон сууц, халуун ус, зочид буудал, цэвэр усны орлого 8.0-40.8 хувиар өсч, хог тээвэрлэлт, иргэдийн үйлчилгээний орлого 12.1-50.0 хувиар буурсан байна.

Ахуйн үйлчилгээний салбарын дүнгээр 816.3 сая төгрөгийн үйлчилгээ явуулж, орлого өнгөрсөн оны мөн үеэс 24.5 хувиар буурчээ. Нийт орлогын 57.4 хувийг барьцаалан зээлдүүлэх, 23.1 хувийг үсчин, 8.0 хувийг прокат ба тоглоомын цэг, 5.1 хувийг гэрэл зураг, 4.4 хувийг гутал засвар, 1.3 хувийг хими цэвэрлэгээ, 0.5 хувийг телевизор засвар, 0.2 хувийг цаг засварын орлого эзэлж байна.

Бусад мэдээлэл

Байгаль цаг агаарын хувьд сарын дундаж температур 15.8 хэмийн дулаан байж, өнгөрсөн оны мөн үеэс 0.5 хэмээр сэрүүн, хур тунадас 141.4 мм-ээр бага байна.

7 сард аж үйлдвэрийн салбарт нарийн боов үйлдвэрлэдэг “Бодь-Агь” ХХК, сүлжмэл эдлэл үйлдвэрлэлийн 1, оёдлын 2, талх, нарийн боов үйлдвэрлэлийн 1 иргэний мэдээллийг, барилгын салбарт Батжин-Ундрах ХХК, Хантэс ХХК, Мусрум ХХК, Алтайн-Арслан ХХК-ийг шинээр статистик мэдээнд хамрууллаа.

АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО,

сая төгрөг

BUDGET REVENUE

	2012	2013			2013/2012=%
		Төлөвлөгөө Plan	**Гүйцэтгэл** Execution	**Биелэлт** Fulfilment	
Нийт орлого ~TOTAL REVENUE	**32586.0**	**19989.8**	**21287.9**	**106.5**	**65.3**
Урсгал орлого	32350.1	19989.8	21287.9	106.5	65.8
Татварын орлого	32002.2	19925.6	21097.3	105.9	65.9
1.Орлогын албан татвар	10853.9	12094.1	11811.3	97.7	108.8
~Хүн амын орлогын албан татвар	10853.9	12094.1	11811.3	97.7	108.8
From populations					
Өмчийн татвар	1629.8	1700.4	3214.2	189.0	197.2
Тусгай зориулалтын орлого	515.1	430.0	613.9	142.8	119.2
Бусад татвар	19003.4	5701.1	5457.9	95.7	28.7
Other taxes					
Татварын бус орлого	347.9	64.2	190.6	3.0 дах	54.8
Non-tax revenue					
Хөрөнгийн орлого	235.9				
Property income					
Тусламжийн орлого					

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА,
зардлаар, сая төгрөг

	2012	2013*			2013/2012=%
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	
НИЙТ ЗАРЛАГА TOTAL EXPENDITURE	**4889.5**	**27197.3**	**25549.3**	**93.9**	**5.2 дах**
Цалин хөлс Wages and salaries	1449.4	10999.0	10850.6	98.7	7.5 дах
Нийгмийн даатгалын шимтгэл Social contributions	147.8	1211.3	1175.9	97.1	8.0 дах
Бараа үйлчилгээний зардал Expenditure on goods & services	1833.2	4864.4	4241.3	87.2	2.3 дах
Татаас ба урсгал шилжүүлэг	91.5	6364.7	6102.2	95.9	66.7 дах
Хөрөнгийн зардал	1367.6	3757.9	3179.3	84.6	2.3 дах

Орон нутгийн төсвийн зарлага, салбараар, сая төгрөг

	2012	2013*			2013/2012=%
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	
Нийт зардал	**4889.5**	**27197.3**	**25549.3**	**93.9**	**5.2 дах**
Нийтийн ерөнхий үйлчилгээ	2522.8	3758.7	3399.9	90.5	134.8
Нийгмийн хэв журам, аюулгүй байдал		-	-		
Боловсрол		12473.9	12193.9	97.8	
Эрүүл мэнд		730.3	727.3	99.6	
Нийгмийн даатгал, нийгмийн халамж		4554.5	4414.6	96.9	
Орон сууц нийтийн аж ахуй		-	.		
Амралт спорт соёл урлаг		649.4	573.2	88.3	
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй	46.1	38.0	38.0	100.0	82.4
Тээвэр холбоо		-	-		
Эдийн засгийн бусад	119.8	244.0	204.8	83.9	171.0
Ангилагдаагүй бусад зардал	2200.8	4748.5	3997.6	84.2	181.6

Тайлбар: *****-*Төсвийн байгууллагын удирлага санхүүжилтийн тухай МУ-ын хууль хүчингүй болж, 2013.01.01-ээс Төсвийн тухай МУ-ын хууль шинээр хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор төсвийн 19 байгууллагаас бусад нь орон нутгийн төсвөөс санхүүждэг болсон.*

БАНКНЫ МЭДЭЭЛЭЛ

(***сая.төг)***

		2012	2013	2013/2012=%
Кассын орлого	МБ-ны зузаатгалаар	98615.0	81985.0	83.1
	Гүйлгээнээс татсан	748791.1	828014.5	110.6
Кассын зарлага	МБ-нд шилжүүлсэн	74425.3	77175.8	103.7
	Гүйлгээнд гаргасан	816888.2	895780.1	109.7
Зээлийн өрийн үлдэгдэл		131651.7	184053.9	139.8
Үүнээс:	Хугацаа хэтэрсэн зээл	822.3	1013.9	123.3
	Зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	0.6	0.6	0.0
	Чанаргүй зээл	784.5	2597.4	331.1
	Зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	0.6	1.41	0.82
Иргэдийн мөнгөн хадгаламжийн үлдэгдэл		85799.3	99373.6	115.8
1 хүнд ногдох хадгаламж *(мян.төг)*		961.1	1099.7	114.4
1 хадгаламж эзэмшигчид ногдох хадгаламж *(мян.төг)*		1164.4	1174.1	100.8

АРИЛЖААНЫ БАНКНЫ ХАДГАЛАМЖ

	Хадгаламж сая.төг		2013/2012=%	Хадгаламж эзэмшигч		2013/2012=%
	2012	**2013**		**2012**	**2013**	
Хадгаламж банк	9003.6	10472.7	116.3	6255	9548	152.6
Голомт банк	13862.6	15107.3	109.0	5321	5557	104.4
ХХБанк	18535.0	19950.4	107.6	6185	6995	113.1
Хаан банк	22815.3	24661.7	108.1	39228	40961	104.4
Төрийн банк	2355.7	2605.3	110.6	1509	1646	109.1
Хас банк	14087.0	21094.5	149.7	13515	17830	131.9
Капитал	3313.8	3317.0	100.1	1161	1374	118.3
Капитрон	1826.3	2164.7	118.5	513	725	141.3
НИЙТ ДҮН	**85799.3**	**99373.6**	115.8	**73687**	**84636**	114.9

Хэрэглээний үнэ тарифын индекс , 2013 оны 07 сарын байдлаар

	2013 он							Суурь үе		
	1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар	6-р сар	7-р сар	2010. 12.21	2012. 07.21	2012. 12.21
Хүнсний бараа	108.4	103.8	100.2	104.1	100.9	97.7	99.0	147.8	106.8	113.8
Гутал хувцас бөс бараа	100.4	103.3	98.5	101.4	100.8	101.9	100.1	149.0	127.8	107.9
Орон сууц	100.0	100.6	102.5	100.0	99.9	106.6	99.3	135.7	120.6	108.8
Гэр ахуйн бараа	100.2	99.5	101.4	101.0	102.2	110.2	100.0	141.5	125.9	114.8
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	99.1	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	111.2	102.3	100.0
Тээвэр	100.0	104.2	100.0	100.0	100.0	109.3	100.0	140.8	116.0	114
Холбооны хэрэгсэл шуудангийн үйлчилгээ	99.6	99.6	98.0	100.0	100.1	99.1	101.1	96.5	97.9	99.4
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээ	100.0	105.7	112.5	100.0	99.3	99.9	98.5	123.7	108.9	110.5
Боловсролын үйлчилгээ	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	127.3	107.4	100.0
Бусад бараа үйлчилгээ	100.1	100.3	102.2	100.8	100.0	100.2	100.0	116.4	109.2	103.8
Ерөнхий индекс	**102.7**	**102.5**	**100.4**	**101.7**	**100.5**	**101.9**	**99.6**	**139.6**	**114.4**	**109.5**

АЖИЛГҮЙЧҮҮДИЙН ТОО
NUMBER OF UNEMPLOYED PERSONS

	2012	2013	2013/2012=%
Бүртгэлтэй ажилгүйчүүд	1822	1892	103.8
Үүнээс: *эмэгтэй*	923	1066	115.5
Ажилгүйчүүд насны бүлгээр			
15-24	609	810	133.0
25-34	824	821	99.6
35-44	269	223	82.9
45-59	120	38	31.7

НИЙТ БИЙ БОЛСОН АЖЛЫН БАЙР

	2012	2013	2013/2012=%
Бүгд	967	1860	192.3
Үүнээс: *~эмэгтэй*	520	1070	2.0 дах
Төрийн, төсөвт байгууллага	45	134	3.0 дах
Нөхөрлөл, компани	435	810	186.2
Хоршоо	2	77	38.5 дах
Бусад	485	839	173.0
үүнээс: *нийтийг хамарсан ажил*	391	699	178.8

ШИНЭЭР БҮРТГЭГДСЭН АЖИЛГҮЙЧҮҮД

	2012	2013	2013/2012=%
Нэмэгдсэн ажилгүйчүүд	557	1817	326.2
Үүнээс: *~эмэгтэй*	199	1142	5.7 дах
Орон тооны цомхтголоос	4	42	10.5 дах
Байгууллага татан буугдсанаас	8	55	6.9 дах
Өөр газраас шилжиж ирсэн	64	93	145.3
Сургууль төгссөн	68	457	6.7 дах
Цэргээс халагдсан	6	23	3.8 дах
Мэргэжлийн ажил олдохгүйгээс	-	-	
Цалин багатайгаас	-	-	
Бусад	407	1147	2.8 дах

АЖИЛД ОРОГСОД, *эдийн засгийн салбарын ангиллаар*

№	Эдийн засгийн салбар	2012		2013	
		Бүгд	үүнээс: эмэгтэй	Бүгд	үүнээс: эмэгтэй
1	**Нийт дүн**	**967**	**520**	**1860**	**1070**
2	ХАА, ан агнуур, ойн аж ахуйн, загас барилт, ан агнуур	60	30	138	62
3	Уул уурхай, олборлолт	15	6	54	18
4	Боловсруулах үйлдвэрлэл	38	23	353	198
5	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	-	-	16	9
6	Усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	-	-	16	6
7	Барилга	23	13	115	33
8	Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	178	97	223	96
9	Тээвэр болон агуулахын үйл ажиллагаа	33	17	52	26
10	Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	52	39	40	26
11	Мэдээлэл, холбоо	11	6	19	8
12	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	13	5	41	32
13	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	-	-	1	-
14	Мэргэжлийн, шинжлэх ухааны болон техникийн үйл ажиллагаа	1	-	2	2
15	Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	14	7	5	1
16	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	1	1	113	66
17	Боловсрол	39	28	69	46
18	Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	-	-	52	38
19	Урлаг, үзвэр, тоглоом наадам	4	2	19	7
20	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	485	246	526	395
21	Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа, өрхийн өөрийн хэрэглээнд зориулан үйлдвэрлэсэн, нэр төрлөөр нь салгаж тодорхойлох боломжгүй бүтээгдэхүүн, үйлчилгээ	-	-	1	1
22	Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	-	-	5	-

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

		Хүний тоо		2013/2012=%	Олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламж *(сая.төг)*		2013/2012=%
		2012-VII	2013-VII		2012-VII	2013-VII	
Халамжийн тэтгэвэр		**2068**	**2182**	**105.5**	**1061.5**	**1449.3**	**136.5**
Нөхцөлт мөнгөн тэтгэмж		**1795**	**1923**	**107.1**	**439.2**	**580.7**	**132.2**
үүнээс:	ахмад настныг асарч буй иргэнд	857	789	92.1	201.3	226.9	112.7
	хөгжлийн бэрхшээлтэй иргэнд	852	828	97.2	212.1	244.5	115.3
	бүтэн өнчин хүүхэд асран хамгаалж харгалзан дэмжигчид	52	53	101.9	16.1	17.1	106.2
	Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг гэр бүлдээ авч асран хамгаалж байгаа	22	24	109.1	7.0	8.1	115.7
	Хүүхэд, төрөл садангүй, ганц бие ахмад настныг гэр бүлдээ авч асран хамгаалж байгаа	9	5	55.6	2.1	1.6	76.2
	Хүүхэд, төрөл садангүй, ганц бие хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг гэр бүлдээ авч асран хамгаалж байгаа	3	1	33.3	0.6	0.3	50.0
	16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж		223			82.2	
Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэнд үзүүлэх хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж		**1645**	**2816**	171.2	**106.2**	**442.3**	**4.2 дах**
үүнээс:	3 хүртэлх насны ихэр хүүхдэд жилд нэг удаа	23	2	8.7	3.8	0.2	5.3
	байнгын асаргаа шаардлагатай иргэнд улиралд нэг удаа	1547	2567	165.9	87.7	150.5	171.6
	3 ба түүнээс дээш тооны (14 хүртэлх насны) хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт жилд нэг удаа	50	64	128.0	2.9	7.5	2.6 дах
	2 ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрхөд, 1 удаа		130			224.0	
	18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэнд нэг удаа	3	14	4.7 дах	1.5	15.4	10.3 дах
	Гэнэтийн аюул ослын улмаас орон гэргүй болсон өрхөд нэг удаа	19	17	89.5	9.5	18.3	2.0 дах
	Нэг удаагийн тусламж	3	8	2.7 дах	0.8	9.6	12.0 дах
	Хорих ангиас суллагдсан өөрийн гэр орондгүй иргэнд		14		-	16.8	
Ахмад настай,ХБИ-дэд олгосон тусламж, хөнгөлөлт		**3815**	**4725**	123.9	**144.4**	**190.0**	**131.6**
үүнээс:	ахмад настанд үзүүлсэн	3647	4074	111.7	92.3	129.9	**140.7**
	хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн	168	651	3.9 дах	52.1	60.1	**115.4**
Хүн амын хөгжлийг дэмжих чиглэлийн улсын төсвийн санхүүжилт		**9324**	**9629**	103.3	**1379.2**	**1452.0**	**105.3**
үүнээс:	хүүхдийн мөнгөн тэтгэмж	-	-		-	-	
	шинээр төрсөн хүүхдэд мөнгөн тусламж	-	-		-	-	
	шинэ гэр бүлд олгосон мөнгөн тусламж	-	-		-	-	
	жирэмсэн болон хөхүүл эхчүүдийн мөнгөн тэтгэмж	3411	3705	108.6	530.0	639.4	**120.6**
	алдарт эхийн одонтой эхчүүдэд олгосон мөнгөн тусламж	5857	5869	100.2	795.6	781.7	98.3
	алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт	56	55	98.2	53.6	30.9	57.6
	МУ-ын болон хөдөлмөрийн баатар, ардын ба гавьяат цолтнуудад төрөөс олгосон нэмэгдэл	-	-		-	-	
Хишиг хувь		99775	11071	11.1	20193.2	820.6	4.1
Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ		68	135	198.5	19.1	37.9	2.0 дах
НИЙТ ДҮН		**118490**	**32481**	27.4	**23342.8**	**4972.8**	**21.3**

ТЭТГЭВЭР ТЭТГЭМЖИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА

			2012-VII	2013-VII			2013/2012=%
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	%	
1. Орлогын дүн			**20539.7**	**24950.0**	**28376.6**	**113.7**	**138.2**
	Тэтгэвэр		13120.8	15800.0	18274.8	115.7	139.3
	Тэтгэмж		950.9	1800.0	1966.9	109.3	206.8
	ҮОМШӨ		1551.5	2000.0	2287.9	114.4	147.5
	Ажилгүйдэл		910.8	450.0	481.5	107.0	52.9
	Эрүүл мэндийн даатгал		4005.7	4900.0	5365.5	109.5	133.9
2. Зарлагын дүн			**15094.8**	**18488.2**	**18800.8**	**101.7**	**124.6**
	Тэтгэвэрт		13140.4	16400.0	16769.1	102.3	127.6
	Эрүүл мэндийн даатгал		1823.1	1880.0	1837.5	97.7	100.8
	Ажилгүйдэл		131.3	208.2	194.2	93.3	147.9
3.Тэтгэвэр авагчдын тоо			**11116**		**11059**		**99.5**
үүнээс:	*~өндөр нас*		6782		6795		100.2
	~тахир дутуу		3201		3207		100.2
	~тэжээгчээ алдагч		1133		1057		93.3
бүгдээс	**Тухайн сард тэтгэврийн мөнгөө авсан хүний тоо**		**10766**		**10994**		**102.1**
	үүнээс:	*~өндөр нас*	6773		6861		101.3
		~тахир дутуу	3096		3158		102.0
		~тэжээгчээ алдагч	897		975		108.7
4. Тэтгэвэр тогтоогдсон хүний тоо			**429**		**642**		**149.7**
үүнээс:	*~өндөр нас*		254		420		165.4
	~тахир дутуу		125		172		137.6
	~тэжээгчээ алдагч		50		50		100.0

Эрүүл мэндийн газрын мэдээгээр

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ҮЗҮҮЛЭЛТ

		2012		2013		Харьцуулсан хувь	
		бодит тоо	үзүүлэлт	бодит тоо	үзүүлэлт	бодит тоо	үзүүлэлт *(продицимилээр)*
1000 хүнд							
Амаржсан эх		1455	16.3	1602	17.7	110.1	1.4
Number of mother delivered							
Төрөхийн улмаас эндсэн эх		-	-	-	-		
Maternal deaths							
Нас баралт	Deaths	343	3.8	294	3.2	85.7	-0.6
1 хүртэл насандаа эндсэн хүүхэд		24	16.4	15	9.2	62.5	-7.2
Infant deaths under age 1 year							
1-5 хүртэл насандаа эндсэн хүүхэд		5	3.4	1	0.6	20.0	-2.8
Infant deaths at age of 1-5 years							
10000 хүнд							
Халдварт өвчнөөр өвчлөгсөд - бүгд		**576**	**64.5**	**461**	**51.0**	**80.0**	**-13.5**
Infectious disease casestotal							
